# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 он 05 дугаар сарын 24-ны өдөр

Чойр хот

<table>
<tr><th>Д/д</th><th>Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж</th><th>Төсөв</th><th>Шалгуур үзүүлэлт</th><th>Суурь түвшин</th><th>2025 онд хүрэх зорилтот түвшин</th><th>Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/</th><th>Гүйцэтгэлийн хувь</th></tr>
<tr><td colspan="8">Зорилго 1. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.</td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.</td></tr>
<tr><td>1.1.1</td><td>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.</td><td>-</td><td>Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь</td><td>Лавлагаа шатлалын эмнэлэг, Өрх, сумын эрүүл мэндийн төвийн нэхэмжлэлийн хяналтын цахим өгөгдөлд дүн шинжилгээ хийж улсын байцаагчийн 68 заалт бүхий зөвлөмж 6 удаа хүргүүлсэн.</td><td>Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.</td><td>2025 оны эхний 5 дугаар сарын 20-ны байдлаар давхардсан тоогоор 149 эрүүл мэндийн байгууллагын 32 багц тусламж, үйлчилгээний 5,386 анхан шатны баримтад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлсэн. Үүнээс:<ul><li>Байцаагч - 8 эрүүл мэндийн байгууллагын 2,041 түүвэр</li><li>Эмч – 141 эрүүл мэндийн байгууллагын 3,345 түүвэрт хяналт хийснээс:</li></ul><hr>Шалгуур хангаагүй шалгуураар хасагдсан:<ul><li>Байцаагч - 228 даатгуулагчийн 20,1 сая төгрөг</li><li>Эмч – 251 даатгуулагчийн 283,7 сая төгрөг</li></ul><hr>Анхан шатны баримт ирүүлээгүй хасалт:<ul><li>Эмч -19 ддатгуулагчийн 13,9 сая төгрөгийн хасалтыг тус тус тооцсон байна.</li></ul><hr>Гэрээ бүхий анхан шатны 3 эрүүл мэндийн байгууллагын 1-4 дугаар сард 3,122 иргэн даатгуулагчид үзүүлсэн 8 багц тусламж</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний гүйцэтгэлд нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлж 94 даатгуулагчийн 5,1 сая төгрөгийн хасагдал тооцсон байна. Мөн гэрээт 5 эмийн сангийн 1-5 дугаар сарын гүйцэтгэл болох 6,702 цахим жорыг хянан баталгаажуулж 217,9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон. Тайлант хугацаанд хийгдсэн нэхэмжлэлийн хяналтын цахим өгөгдөлд дүн шинжилгээ хийж гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын даатгал хариуцсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тухай бүр мэргэжил арга зүйгээр ханган ажиллав.<br>**Үр дүн: 2025 оны 1 - 4 сарын түүвэрт нэхэмжлжлэлийн хяналтыг хийж, мэргэжил арга зүйгээр хангав. Хэрэгжилтийн хувь 100** | |
| 1.1.2 | Эрүүл мэндийн даатгалын 2023, 2024 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна. | - | Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо | Эрүүл мэндийн даатгалын 2023, 2024 оны статистик мэдээллийн эмхэтгэл гараагүй. | Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын 2023, 2024 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллээр эмхтгэл бэлтгэх ажил хийгдээгүй байна. | 100 |
| 1.1.3 | “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | ЭМДҮЗ-ийн 2024 оны 05, 06, 14 дүгээр тогтоолыг гэрээт 5 эрүүл мэндийн байгууллагад танилцуулан, 3 удаагийн сургалт | Шинэчлэгдсэн журмыг Эрүүл мэндийн байгууллагуудад танилцуулж, хяналт тавин ажилласан байна. | 2025 онд шинээр батлагдсан ЭМДҮЗ-ийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 03, “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 04, Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 11 дүгээр тогтоолуудыг анхан болон лавлагаа шатлалын гэрээт 5 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж 3 удаагийн сургалт зохион байгуулсан. Дээрх тогтоолуудын хэрэгжилттэй холбоотой цаг үеийн асуудлаар эрүүл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулсан. | | мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүй, шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр ханган ажиллаж байна. ЭМДЕГ-аас дээрхи тогтоолуудыг танилцуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтад гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг бүрэн хамруулсан. **Үр дүн: Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад хийсэн сургалтын мэдээллийг ОНХХ-т хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь 100** | |
| 1.1.4 | ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ 2024 оны 05 дугаар тогтоолыг мөрдөж байна. Гэрээт анхан шатны 3 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан. | Шинэчлэгдсэн журмыг эрүүл мэндийн байгуулагуудад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна. | 2025 онд шинээр батлагдсан "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолыг гэрээт анхан шатны 3 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан бөгөөд тус эрүүл мэндийн байгууллагуудын 1-4 дүгээр сард 3,122 иргэн даатгуулагчид үзүүлсэн 8 багц тусламж үйлчилгээний гүйцэтгэлд хийсэн нэхэмжлэлийн хяналтаар 94 даатгуулагчийн 5,1 сая төгрөгийн хасагдал тооцсон байна. **Үр дүн: 2025 оны 1 - 4 сарын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд нэхэмжлжлэлийн хяналтыг хийж, мэргэжил арга зүйгээр хангав. Хэрэгжилтийн хувь 100** | 100 |
| 1.1.5 | Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана. | - | - Санхүүжүүлсэн мөнгөн дүн -Хамрагдсан даатгуулагчийн тоо | ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна. 2024 онд 135 иргэнд 23,8 сая төгрөгийн санхүүжилт | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна. | 2025 оны эхний 5 сарын байдлаар эрт илрүүлэг үзлэг оношилгоо, шинжилгээнд хамрагдсан 13 иргэн даатгуулагчийн 2,070,0 мянган төгрөгийн санхүүжилтэнд хяналт тавьж олгохоор тооцсон. **Үр дүн: Хэрэгжилтийн хувь 100** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | олгохоор тооцсон. | | | |
| 1.1.6 | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ. | - | Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо | Гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний саналыг хүргүүлж ажилласан. | Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна. | Даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд эхний 4 сарын байдлаар хяналт, дүн шинжилгээ хийх ажил 60 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.<br>**Үр дүн: Хэрэгжилтийн хувь 60** | 60 |
| 1.1.7 | “ЭМДС-гаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар , хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана. | | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг мөрдөж байна. Гэрээ бүхий 6 эмийн санд жагсаалтыг хүргүүлэн хяналт тавьж ажилласан. | Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг холбогдох нэгжид тайлагнасан байна. | “ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт 5 эмийн санд анхан болон лавлагаа шатлалын 5 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. Мөн гэрээт 5 эмийн сангийн 1-4 дүгээр сарын гүйцэтгэл болох 6,702 цахим жорыг хянан баталгаажуулж 217,9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон ба 1 эмийн санд 3 заалт бүхий улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.<br>**Үр дүн: Хэрэгжилтийн хувь 100** | 100 |
| Зорилт 1.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4-т заасан “Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно” зорилтын хүрээнд: | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.1 | *БСТ 2.1.3, БГТ-1.4.3*<br><br>Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө. | - | Хүргүүлсэн саналын тоо | Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад 3 удаа санал хүргүүлсэн. | Эрх зүйн баримт бичигт холбогдох санал ЭМДҮЗ-ийн 10 тогтоол, 4 журамд санал боловсруулж хүргүүлсэн байна. | "Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журам"-ын төсөлд санал хүргүүлсэн.<br><br>**Үр дүн: Журмын төсөлд санал хүргүүлсэн.** | 100 |
| 1.2.2 | Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана. | - | Зөрчлийн хэргийн тоо | 2024 онд аймгийн Прокурорын байгууллагатай хамтран гэмт хэрэгт холбогдсон 28 иргэний 12,1 сая төгрөгийг санд төвлөрүүлсэн. | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна. | 2025 оны эхний 4 сарын байдлаар нэхэмжлэлийн хяналт болон иргэн даатгуулагчаас гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй тул зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа явуулаагүй байна.<br>Тайлант хугацаанд Зөрчлийн тухай хууль тогтоомж, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааны талаар аймгийн Прокурорын газраас эрх бүхий албан тушаалтнуудад зохион байгуулсан танхимын 2, ажлын байран дээрх 1, нийт 4 удаагийн сургалтад албан хагчид бүрэн хамрагдсан<br>**Үр дүн: Зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол ирээгүй болно.** | 100 |
| **2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.** | | | | | | | |
| 2.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-т заасан "Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ" зорилтын хүрээнд: | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | *ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ 2.1.1*<br><br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 46. | 2025 онд 50 хувиас дээш хамруулна | Төлөвлөгөө 171 | Гүйцэтгэл 106 | 62% | 94,8 |
| | | | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 96. | 2025 онд 90 хувиас дээш хамруулна. | Төлөвлөгөө 67 | Гүйцэтэл 231 | 344,8% | |
| | | | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМД-д хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 31. | 2025 онд 40 хувиас дээш хамруулна. | Төлөвлөгөө 343 | Гүйцэтгэл 184 | 53,6% | |
| | | | -Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 100 | 2025 онд 90 хувиас дээш хамруулна. | Төлөвлөгөө 3765 | Гүйцэтгэл 3601 | 95,6% | |
| 2.1.2 | Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ. | - | Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо | 2024 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих тайлан мэдээг гарган жилд 3 удаа ЭМДЕГ-т хүргүүлсэн. | Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн байгууллагад олгосон санжүүжилтийг сар бүр программын олголттой тулган, тооцоо нийлэн ажиллаж байна.<br><br>**Үр дүн: Гэрээ бүхий эрүүл мэндийн байгуулагуудтай сар бүр өглөг авлагаа тулган, тооцоо нийлж, хасагдлын талаарх албан тоотыг тухай бүр хүргүүлсэн.** | | | 100 |
| 2.1.3 | *ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7,* | | Төвлөрүүлсэн мөнгөн дүн | 2024 онд орлогын төлөвлөгөөни | ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 90 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | Төлөвлөгөө – 2,130,924.4 мян.төг<br><br>Гүйцэтгэл – 2,185,115.1 мян.төг | | | 102.5 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана. | | | й биелэлт 101.5 хувьтай байна. | | Биелэлт - 102.5% | |
| 2.2 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2-т заасан “Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 2.2.1 | *БСТ 2.2.1, БГТ-2.2.1* Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна. | ЭМДС | Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан | 2024 онд 399.7 сая төгрөгийн өглөгтэй тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн. | Өглөг, авлага барагдуулах чигэлээр арга хэмжээ авч ажилласан байна | Гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагууд 2025 оны 5 дугаар 20-ны байдлаар нийгмийн даатгалын шимтгэл болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн өр, авлагагүй байна. | 100 |
| **3.** Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна. | | | | | | | |
| 3.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1-т заасан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 3.1.1 | *БСТ 3.1.2, БГТ 3.1.1*<br><br>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна. | - | Гэрээ дүгнүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 2024 онд гэрээт 11 ЭМБ-ын гэрээг дүгнэсэн. | Гэрээт ЭМБ-уудын гэрээг хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. | Даатгалын гэрээ бүхий 11 эрүүл мэндийн байгууллагын гэрээг дүгнэсэн. | 86,0 |
| | | | Гэрээний хэрэгжилтийн хувь | 2024 онд гэрээний хэрэгжилт 94,2 | Гэрээний хэрэгжилтийн хувь 90 ээс доошгүй байна. | 1. Нэгдсэн эмнэлэг – 80<br>2. Энхбилиг эмнэлэг – 80<br>3. Энхтусдэм ӨЭМТ – 94.6<br>4. Шивээговь СЭМТ – 71.9<br>5. Баянтал СЭМТ – 64.6<br>6. Ансот эмийн сан – 95<br>7. Говийн Сондор эмийн сан – 95<br>8. Эко эмийн сан – 95<br>9. Их догшин эмийн сан – 90<br>10. МЭИК эмийн сан – 95<br>11. Нинж фарм – 85<br>**Үр дүн: Хэрэгжилтийн хувь 86** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2 | 2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна. | | Шинэчлэн байгуулсан гэрээний тоо | Гэрээ бүхий 6 эмийн сантай гэрээ байгуулж, дүгнэх ажлыг хагас бүтэн жилээр зохион байгуулж ажилласан. Шинээр 1 эмийн сан гэрээ байгуулахад арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | Эрүүл мэндийн байгуулагуудтай гэрээ байгуулагдсан байна. | 2025 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээг<br>• Лавлагаа шатлалын - 2<br>• Анхан шатны - 3<br>Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх 6 эмийн сантай гэрээ байгуулсан.<br>2025 оны 3 дугаар сарын 1-нээс Нинж фарм эмийн сан өөрийн хүсэлтээр гэрээ цуцлах хүсэлт гаргасан.<br>**Үр дүн: 2025 онд 11 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулсан. Хэрэгжилтийн хувь 100** | 100 |
| 3.1.3 | Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг хантан ажиллана. | | Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан | Лавлагаа шатлалын 2, СЭМТ-2, ӨЭМТ-1, эмийн сан -6 гэрээ бүхий байгууллагад 3 удаа мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан. | Журамд орсон өөрчлөлтийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг хангаан ажиллаж тайлагнасан байна. | Чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх талаар 2025 онд шинэчлэн батлагдсан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын "Журам шинэчлэн батлах тухай" 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/30 тоот тушаалыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд уг тушаалын талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад мэдээлэл хүргэж ажилласан.<br>**Үр дүн: Шинэлэгдсэн журмыг гэрээ бүхий 5 эрүүл мэндийн байгууллагад танилцуулсан.** | 100 |
| 3.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2-т заасан "Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 3.2.1 | *БГТ 3.2.1*<br>Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. | ЭМДС | Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн, | Нийт 11 ЭМБ-ын 12,221,9 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийг хянаж 11,650,7 тэрбум | Хуваарилагдсан түүвэрт нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хугацаанд нь журмын дагуу хэрэгжүүлсэн байна. | **Улсын эмнэлэг**<br>(Хүний тоо / Мөнгөн дүн)<br>Нэхэмжилсэн: 23,278 / 2,386,362.6<br>Эмчийн хасагдал: 14 / 7,985.4 | 100 |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>төгрөгийн гүйцэтгэл олгохоор тооцсон.</td>
<td></td>
<td>
<table>
<tr><td>Байцаагчийн хасагдал</td><td>63</td><td>4,536.0</td></tr>
<tr><td>Эх олонлог</td><td>201</td><td>25,131.6</td></tr>
<tr><td>Цахим</td><td></td><td>27,772.0</td></tr>
<tr><td>Олгохоор тооцсон</td><td>23,000</td><td>2,320,937.6</td></tr>
<tr><td colspan="3">Хувийн эмнэлэг</td></tr>
<tr><td>Нэхэмжилсэн</td><td>2,435</td><td>290,009.3</td></tr>
<tr><td>Эмчийн хасагдал</td><td>2</td><td>1,172.8</td></tr>
<tr><td>Эх олонлог</td><td>3</td><td>1,624.3</td></tr>
<tr><td>Цахим</td><td></td><td>26.3</td></tr>
<tr><td>Олгохоор тооцсон</td><td>2,430</td><td>287,185.9</td></tr>
<tr><td colspan="3">Өрх, сумын эмнэлэг</td></tr>
<tr><td>Нэхэмжилсэн</td><td>3,122</td><td>283,963,1</td></tr>
<tr><td>Эмчийн хасагдал</td><td>94</td><td>5,067,9</td></tr>
<tr><td>Цахим</td><td></td><td>3,274,8</td></tr>
<tr><td>Олгохоор тооцсон</td><td>3,028</td><td>275,620,4</td></tr>
</table>
</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>3.2.2</td>
<td>БГТ 3.2.3<br>Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.</td>
<td>-</td>
<td>Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо</td>
<td>2024 онд 11 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.</td>
<td>Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.</td>
<td>Тайлант хугацаанд гэрээ бүхий лавлагаа шатлалын 2, анхан шатны 3, нийт 5 эрүүл мэндийн байгууллагад нэхэмжлэлийн хяналтаар зонхилон илэрч буй дутагдал, дутагдлыг арилгуулах чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Мөн 2025 онд шинээр батлагдсан “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолыг гэрээт анхан шатны 3 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж дээрх тогтоолуудын хэрэгжилттэй холбоотой цаг үеийн асуудлаар эрүүл мэндийн</td>
<td>100</td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагуудыг мэргэжил арга зүй, шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр ханган ажилласан. **Үр дүн: Гэрээ бүхий 5 эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.** | |
| 3.2.3 | Гэрээт ЭМБ-уудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна. | - | Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 2024 онд нийт улсын байцаагчийн 6 зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг хянаж ажилласан. | Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | 2024 оны 7-12 сарын гүйцэтгэлд нэхэмжлэлийн хяналтын цахим өгөгдөлд дүн шинжилгээ хийж гэрээт лавлагаа шатлалын 2, анхан шатны 3, эмийн сан 1, 34 заалт бүхий улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. **Үр дүн: 6 эрүүл мэндийн байгууллагад улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн.** | 100 |
| 3.2.4 | *БСТ 3.2.3, БГТ-3.2.2* Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, санал үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ. | - | Хяналт, шалгалтад хамрагдсан байгууллагын тоо Хяналт шалгалтын тайлан | 2024 онд гэрээт 3 ЭМБ-д газар дээрх хяналт шалгалтыг зохион байгуулсан. | Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | Гэрээт 5 эмийн санд ЭМДҮЗ-ийн 11 дүгээр тогтоолын хэрэгжилт, зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр газар дээрх хяналтыг хэрэгжүүлж, хяналтаар илэрсэн дутагдлыг арилгуулах чиглэлээр 1 эмийн санд 3 заалт бүхий улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж, мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. **Үр дүн: Гэрээт 5 эмийн санд газар дээрх хяналт хэрэгжүүлсэн.** | 100 |
| **4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | | |
| 4.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1-т заасан “Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө” зорилтын хүрээнд. | | | | | | | |
| 4.1.1 | *ЗГҮАХ-2.1.9, БГТ 4.1.3* Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын | - | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, тайлан | Аймаг орон нутгийн чанартай сургалтад хамрагдаж, | Орон нутгийн удирдлагатай хамтран арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. | “Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай” аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/31 тоот захирамжийн дагуу 2 албан хаагч үндсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ. | | | Ерөнхий газраас зохион байгуулсан нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт бүрэн хамрагдсан. | | цалингийн 20 хувийн нэмэгдлийг 2024 оны 01 дүгээр сарын 1-нээс эхлэн олгож хэлсэн.<br>Чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 2025 оны 4 дүгээр сард Төрийн албаны зөвлөлөөс Монгол УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Ес зүй, дэгийн байнгын хороо болон Ёс зүйн хороотой хамтран зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил Төрийн албаны манлайлал” сэдэвт говийн бүсийн зөвлөгөөнд оролцсон. | |
| 4.1.2 | Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна. | | Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо | Нээлттэй хаалганы өдөрлөг 1 удаа | Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна. | 1. Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт 2 удаа оролцож байгууллагын үйл ажиллагааг сурталчилж эрүүл мэндийн даатгалын шимтгэл, төлөлттэй холбоотой 192 ширхэг гарын авлагыг иргэдэд тараасан<br>2. Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран төрийн болон хувийн хэвшлийн 4 байгууллагад эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, шимтгэл төлөлтийн талаар сургалт сурталчилгаа хийж гарын авлага тараасан.<br>3. E-Mongolia, E баримт аппликейшнаар дамжуулан эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг шалгах, хэрхэн төлөх талаар иргэдэд сурталчилах ажил тогтмол хийгдэж байна.<br>4. ЭМДЕГ-аас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг шалгах, төлөх зааврын талаарх 8 төрлийн 102 ширхэг сурталчилгааны материалыг гэрээ бүхий лавлагаа шатлалын 2, анхан шатны 3 эрүүл мэндийн байгууллага, 7 эмийн санд хүргүүлж ажилласан. Дээрхи эрүүл мэндийн байгууллагууд болон эмийн сангууд нь уг сурталчилгааны | 94.8 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | материалуудыг мэдээллийн самбарт байршуулан иргэдэд сурталчилж байна. Мөн тус хэлтсээр үйлчлүүлж буй иргэдэд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөхийн ач холбогдол, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хэрхэн төлөх, шалгах талаар сурталчилж 124 ширхэг гарын авлагыг тараасан. **Үр дүн: Эрүүл мэндийн даатгалын хамралт 94,8 хувьтай байна.** | |
| 4.1.3 | Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ. | - | Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо | 2024 онд 5,120 иргэн, даатгуулагчдад мэдээ, мэдээллийг хүргэсэн. | 2025 онд 150-аас доошгүй иргэн, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын талаарх мэдлэг, мэдээллийг хүргэсэн байна. | Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах чиглэлээр хэлтсийн пейж хуудсаар дамжуулан иргэд, даатгуулагчдыг шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган ажилласан.. Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын пейж хуудсанд нийтлэгдсэн мэдээллийг тухай бүр байгууллагын пейж хуудас болон аймгийн томоохон зарын группуудэд шейрлэж мэдээллийг давхардсан тоогоор 4,390 иргэнд түгээж байна. | 100 |
| 4.1.4 | *БГТ 4.1.8* Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ. | - | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | 80 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэсэн. | Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн байгууллагуудын ажилтан албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг цахимаар авах чиглэлээр ЭМДЕГ-аас ирүүлсэн QR кодыг гэрээт 5 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж 2025 оны 05 дугаар сарын 01-ний байдаар судалгаанд нийт 24 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулсан байна. | 100 |
| 4.1.5 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн | - | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, | Өргөдөл, гомдлын тоо 11 | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн | Тайлант хугацаанд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь 100 хувь шийдвэрлэсэн. Үүнд: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана. | | шийдвэрлэлтийн хувь | шийдвэрлэлт 100 хувь | жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | • Ибаримтаар ЭМД-ын шимтгэл төлөхтэй холбоотой биеэр 105, утсаар 38,<br>• Хуруууны хээний тухай – 5<br>• Төр хариуцах 8 иргэний мэдээллийг цахим системд бүртгэсэн<br>• Овог нэрийн мэдээлэл засуулсан нярай – 1 | |
| 4.1.6 | Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан болон үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллана. | | Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 17 удаа гаргаж хэрэгжилт 100 хувь | Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | Шуурхайн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр Тамгын газарт хүргүүлсэн. | 80 |
| 4.1.7 | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, орон нутгаас зохион байгуулсан ажилд оролцож хэрэгжилтийг хангаж ажиллана. | | Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр хүргүүлж, орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвхитэй хамрагдсан. | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвхитэй оролцсон байна. | Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр буюу 05 дугаар сарын 15-ны өдөр аймгийн цэцэрлэгт хүрээлэнд хэлтсийн хуваарьт талбайд 10 мод шинээр тарьсан.<br>Аймаг болон сумын Засаг даргын тамгын газраас кохион байгуулсан 3 удаагийн бүх нийтийн цэвэрлэгээнд хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдсан.<br>ЭМДЕГ болон аймаг орон нутгийн удирдлагаас цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулдан өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.8 | Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний ГТ-ний биелэлтийн хувь | Хэлтсийн мэргэжилтэнгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажиллана. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна. | Чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж, цаг ашиглалт болон төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавин удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна. | 100 |
| 4.1.9 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Архивын нэгжийн тоо /боть/ | 2024 оны 9 архивын нэгжийг бүрдүүлж, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн. | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна | 2024 оны тусламж, үйлчилгээний баримтыг архивын нэгж болгосон. Үүнд:<br>• Улсын эмнэлэг – 1 боть<br>• Хувийн эмнэлэг – 1 боть<br>• Өрх, сумын ЭМТ- 1 боть<br>• Эмийн сан - 1 боть<br>• Эмийн сангийн гэрээний биелэлт – 1 боть<br>• Тусламж, үйлчилгээний санхүүгийн тайлан – 1 боть<br>• Ирсэн бичиг – 1 боть<br>• Явсан бичиг – 1 боть,<br>**Үр дүн: 8 боть баримт архивт хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.** | 100 |
| 4.1.10 | Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна. | | Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо Хэрэгжилтийн хувь | | Албан хэрэг хөтлөлтийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна. | Төрийн албан хэргийг хос бичгээр 2025 оны 5 дугаар сарын 1-нээс эхлэн хөтлөн явуулж байна.<br><br>**Үр дүн: Хос бичгээр 3 албан бичиг үйлдсэн.** | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.11 | Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ. | | Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо | | Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна. | Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. | 90 |
| 4.1.12 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хانган ажиллана. | | Хэрэгжилтийн хувь | | Хэрэгжилтийг хانган ажилласан байна. | Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ХАСХОМ -ийг 01 дүгээр сарын 28-ны өдөр шинэчлэн гаргаж, байгууллагын эрх бүхий албан тушаалтанд бүрэн, үнэн зөв мэдүүлэн, баталгааны маягтыг хүргүүлсэн. **Үр дүн: Хэлтсийн 2 албан хаагч хугацаандаа, үнэн зөв мэдүүлсэн.** | 100 |
| 5. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх зорилтын хүрээнд | | | | | | | |
| 5.1 | Агентлаг болон бусад байгууллага, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах сургалт, семинарт бүрэн хамрагдана. | | Шинэчлэгдсэн тогтоол, шийдвэрүүдийг бүрэн судалсан эсэх | | Сургалтад бүрэн хамрагдсан байна. | 1. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд агентлагаас зохион байгуулсан сургалтууд болон цаг үеийн шинж чанартай мэдээ мэдээллээр хангах чиглэлээр зохион байгуулсан цахим сургалтуудад албан хаагчид бүрэн хамрагдсан.<br>2. Авилагатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, АЗДТГ, Төрийн албаны Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл, аймгийн Прокурорын газраас Төрийн албан хаагчийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан танхимын 8 удаагийн сургалтад бүрэн хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.4 ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | | Хамрагдсан сургалтын тоо | Нийт цахим болон танхимын 41 удаагийн сургалтад хамрагдсан байна. | ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг, мэдээлэл авсан байна. | ЭМДЕГ-ын сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан цахим сургалтууд болон мэдээллийн цагт албан хаагчид бшрэн хамрагдсан. | 100 |
| 5.3 | Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ. | | Хамрагдсан сургалтын тоо | Сургалт, семинарт бүрэн хамрагдсан. | Сургалт, семинарт бүрэн хамрагдсан байна. | Тайлант хугацаанд:<br>1. ЭМДЕГ-ын даргын “Албан томилолтоор ажилуулах тухай” 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/46 тоот тушаалын дагуу Өмнөговь аймагт 2025 оны 04 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Төрийн албаны зөвлөлөөс Монгол УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Ес зүй, дэгийн байнгын хороо болон Ёс зүйн хороотой хамтран зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил Төрийн албаны манлайлал” сэдэвт говийн бүсийн зөвлөгөөнд 1 албан хаагч оролцож “Төрийн албаны тухай” хуулийн шинэчлэл, хууль тогтоомжийн хэрэглээ, бэрхшээл, шийдэл, төрийн албан хаагчийн ёс зүй, үнэт зүйл, төлөвшил, ажил амьдралын тэнцвэр, дижитал төр, оюун ухааны технологи, карьер хөгжлийн талаар илтгэл, хэлэлцүүлэгт оролцож мэдлэг, чадвараа дээшлүүлсэн.<br>2. Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр Аймгийн Засаг даргын тамгын газар, Төрийн албаны Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан 2 удаагийн нэгдсэн зөвлөгөөн, сургалтад албан хаагчид бүрэн хамрагдаж мэдлэ, чадвараа дээшлүүлсэн.<br>3. Төрийн албан хаагчийн манлайлал, ёс зүйн чиглэлээр ЭМДЕГ-аас зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан цахим сургалтуудад албан хаагчил бүрэн хамрагдсан. | |
| 5.4 | Монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг ахиулах сургалтад хамрагдах | | Хамрагдсан сургалтын тоо | | Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшилж, Монгол бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна. | Монгол бичгийн мэдлэг чадварын түвшмнг дээшоуулэх чиглэлээр албан хаагчид богино хугацаанй цахим сургалтад хамрагдахаас гадна бие даан суралцаж байна. | 100 |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **_Төсвийн шууд захирагч_**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА .................................... (С.ЭНХБОЛД)

......................... *(огноо)*

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн: **Нэгжийн дарга**

ДОТООД АУДИТ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА .................................... (Б.ОЮУНЦЭЦЭГ)

2025-06-24 *(огноо)*

*Тайлагнасан:* **Нэгжийн дарга**

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА .................................... (Б..ОЮУНЦЭЦЭГ)

..........................*(огноо)*